

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэлд:

IX.7. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудыг нийслэлийн Хан-Уул дүүргийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр (Яармаг шинэ төв)-т шилжүүлэн байршуулах төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагуудыг нийслэлийн Хан-Уул дүүргийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр (Яармаг шинэ төв)-т шилжүүлэн байршуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2018 онд багтаан хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод даалгав.

2. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулах төслийг хэрэгжүүлж Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг багасгах чиглэлээр шинэ суурьшлын бүс болох Буянт-Ухаа, Яармаг болон Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэн их, дээд сургуулиудыг хотоос гаргах асуудлыг үе шаттайгаар эхлүүлэх, Улаанбаатар хотыг алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгонтой холбосон авто замын сүлжээ барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх, холбогдох төлөвлөгөө, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зэрэг Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг анхаарч, энэ талаар шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ нарт, хамтран ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР